

ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам”, байгууллагын Дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01-08/03 дугаар удирдамжийг үндэслэн 2025 оны нэгдүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагуудыг дэлгэрэнгүйгээр өссөн дүнгээр харуулбал:

д/д	Байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Мэдээлэх давтамж	Хугацаандаа	Хугацаа хоцорсон мэдээлэл	Хугацаа болоогүй	Хувь
1	2	3	4	5	5	6	7
1	Гадаадын иргэн, харьяатын газар	1	45	44	1	-	97.8
2	Агаарын замын боомт хариуцсан газар	1	45	45	-	-	100.0
3	Дорноговь аймаг дахь газар	1	45	45	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	1	45	45	-	-	100.0
5	Өмнөд бүс дэх газар	1	45	45	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	1	45	45	-	-	100.0
7	Зүүн бүс дэх газар	1	45	45	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	1	45	45	-	-	100.0
Нийт дүн		8	360	359	1	-	99.7

Тус хяналт, шалгалтаар төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтын зохих мэдээллийг анхан шатны баримтад үндэслэн 2025 оны нэгдүгээр улиралд байгууллагын хэмжээнд цахим хуудсанд 360 мэдээлэл байршуулахаас 359 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж 99.7 хувийн үзүүлэлттэй “Хангалттай” үнэлэгдэж байна.

Төв, орон нутаг дахь нэгжүүдээс 2025 оны нэгдүгээр улиралд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан нийт 43 тушаал, шийдвэрийн үндэслэл хэсэг хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт шинжилгээ хийхэд нийт 10 алдаа гарсан байна. Иймд хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг баримтлан ажиллах;
- Дотоод аудитын зөвлөмж, удирдлагаас хүргүүлсэн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан, түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах тул эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын нэгжид албан бичгээр ирүүлнэ үү.

---00000000---